

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баян-Уул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ДОА-2024/01/НА-СТА-ТТЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2024 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: <a href="mailto:bolortuulb@audit.gov.mn">bolortuulb@audit.gov.mn</a> Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:semjidmaai@audit.gov.mn">semjidmaai@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:narmandakhd@audit.gov.mn">narmandakhd@audit.gov.mn</a> Аудитор: Б.Одхүү Утас: 70584207 Цахим хаяг: <a href="mailto:odkhuu@audit.gov.mn">odkhuu@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга  
.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
  - 3.5 ....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.25 № 327

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАЯН-УУЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Х.БАТТУЛГА ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баян-Уул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Уул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөх аудитаар өгсөн алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

#### Аудитын гол асуудал

Дорнод аймгийн Баян-Уул сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 02 дугаар тогтоолоор "хангалттай" гэж дүгнэсэн нь бодитой биш байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

011021225

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>666,923.9</b>	<b>576,339.7</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>294,660.8</b>	<b>263,052.5</b>
33	АВЛАГА	294,660.8	144,477.6
35	БАРАА МАТЕРИАЛ	148,638.8	168,809.6
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,306,505.6</b>	<b>7,883,682.9</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7,306,505.6</b>	<b>7,883,682.9</b>
39200	Биет хөрөнгө	7,251,476.2	7,740,872.0
39300	Биет бус хөрөнгө	55,029.4	142,810.9
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,973,429.5</b>	<b>8,460,022.6</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,444.0</b>	<b>0.0</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,444.0</b>	<b>0.0</b>
41300	Өглөг	1,444.0	0.0
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,971,985.5</b>	<b>8,460,022.6</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,971,985.5</b>	<b>8,460,022.6</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	749,087.5	837,056.5
51200	Хуримтлагдсан үр дүн	7,045,136.6	7,447,549.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	177,761.4	175,416.8
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,973,429.5</b>	<b>8,460,022.6</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,804,517.7</b>	<b>3,639,047.5</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>623,548.2</b>	<b>917,808.6</b>
110	Орлогын албан татвар	505,349.8	725,250.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	520,347.8	740,217.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-14,997.9	-14,967.4
113	Хөрөнгийн албан татвар	48,834.7	92,796.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	69,363.7	99,761.6
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,640,537.6</b>	<b>1,045,559.0</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,640,537.6	1,045,559.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,540,431.9</b>	<b>1,675,679.9</b>
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,024,654.3</b>	<b>2,311,179.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,024,654.3</b>	<b>2,311,179.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,585,399.4</b>	<b>2,064,179.0</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	507,810.5	574,777.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,486.3	79,733.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	208,638.7	578,412.3
2104	Хангамж, бараа материалын зардал	58,115.7	81,168.3
2105	Нормативт зардал	13,010.8	638.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,533.2	46,746.7

БАЯН-УУЛ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2107	Томилолт, зочны зардал	9,988.0	20,262.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,577.4	49,802.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	559,238.8	632,638.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,439,255.0	247,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,779,863.4	1,327,868.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,160,856.4	927,800.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-8,380,993.0	400,068.1

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,427,091.5	0.0	16,427,091.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-74,113.0	0.0	-74,113.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,352,978.5	0.0	16,352,978.5
9	Тайлант үеийн үр дүн	-8,380,993.0	0.0	-8,380,993.0
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,971,985.5	0.0	7,971,985.5
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,971,985.5	0.0	7,971,985.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,344.5	0.0	2,344.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,974,330.0	0.0	7,974,330.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,344.5	0.0	-2,344.5
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	87,969.0	0.0	87,969.0
19	Тайлант үеийн үр дүн	400,068.1	0.0	400,068.1
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	8,460,022.6	0.0	8,460,022.6

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,413,787.1	2,848,249.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	623,548.2	917,808.6
110	Орлогын албан татвар	505,349.8	725,250.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	520,347.8	740,217.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-14,997.9	-14,967.4
113	Хөрөнгийн албан татвар	48,834.7	92,796.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	69,363.7	99,761.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,712.6	5,654.7
1181	Газрын төлбөр	23,387.7	77,674.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	42,263.4	16,432.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	346,807.0	254,760.7
120	Нийтлэг татварын бус орлого	346,807.0	254,760.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,443,431.9	1,675,679.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,550,702.6	1,822,878.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,550,702.6	1,822,878.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,111,447.6	1,575,878.0

БАЯН-УУЛ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	507,810.5	574,777.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,486.3	79,733.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	208,638.7	90,587.7
2104	Хангамж, бараа материалын зардал	58,115.7	77,663.1
2105	Нормативт зардал	2,210.8	638.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,533.2	39,846.7
2107	Томилолт, зочны зардал	9,988.0	20,262.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,577.4	502,269.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,087.1	190,099.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,439,255.0	247,000.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	863,084.6	1,025,371.2
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	975,828.4	1,056,979.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	975,828.4	1,056,979.4
2200	Дотоод эх үүсвэрээр	975,828.4	1,056,979.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-975,828.4	-1,056,979.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-50,000.0	0.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,000.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-162,743.8	-31,608.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	457,404.6	294,660.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	294,660.8	263,052.5

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,674,163,6	2,400,682.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,440,365,1.	1,406,438,5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,439,215,1	1,405,438,5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	546,621,6	539,497,5
210101	Үндсэн цалин	378,946,6	367,969,7
210102	Нэмэгдэл	137,474,6	138,863,0
210104	Урамшуулал	30,200,4	32,664,8
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,425,6	69,141,5
210201	Тэтгэврийн даатгал	49,930,3	47,360,1
210202	Тэтгэмжийн даатгал	5,873,6	5,574,5
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,699,1	4,372,5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,174,2	1,074,3
210205	Эрүүл мэндийн даатгал	11,748,4	10,760,2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	574,230,9	564,567,2
210301	Гэрэл, цахилгаан	79,973,2	71,105,1
210302	Түлш, халаалт	488,368,0	488362,4
210303	Цэвэр, бохир ус	5,889,7	5,099.70
2104	Хангамж, бараа материалын зардал	28,380,0	27,904,1
210401	Бичиг хэрэг	5,800,0	5,799,6
210402	Тээвэр, шатахуун	16,100,0	16,094,0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,0	1,930,5

**БАЯН-УУЛ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,080,0	4,080,0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>21,750,0</b>	<b>21,499,8</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,700,0	7,599,8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400,0	250,0
210604	Урсгал засвар	13,650,0	13,650,0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,200,0</b>	<b>16,814,0</b>
210702	Дотоод албан томилолт	17,200,0	16,814,0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>34,850,0</b>	<b>34,035,4</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,000,0	30,000,0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,0	767,4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600,0	507,8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,0	400,0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,860,0	1,465,0
210807	Газрын төлбөр	990,0	895,2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>142,757,0</b>	<b>131,979,0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	142,757,0	131,979,0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,150,0</b>	<b>1,000,0</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,150,0	1,000,0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,150,0	1,000,0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,188,8</b>	<b>994,2</b>
223001	Бусад хөрөнгө	1,188,8	994,2
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>45,000,0</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	45,000,0	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,674,200.00</b>	<b>2,539,029.40</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,387,403,8</b>	<b>2,244,288,5</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,441,105,3	1,346,109,5
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	946,298,5	898,179,0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>286,759,8</b>	<b>294,740,9</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,800,0	97,781,1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	270,959,8	196,959,8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.00	87,468.50
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.00	225,815,8
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>72.00</b>	<b>72.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2.00</b>	<b>2.00</b>
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>35.00</b>	<b>35.00</b>
620001	Удирдах ажилтан	11.00	11.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
620004	Гэрээт ажилтан	8.00	8.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>35.00</b>	<b>35.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	12.00	12.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00
650010	Гэрээт ажилтан	8.00	8.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.00	9.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>336,62,5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>277,119,5</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>31,119,5</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,339,2</b>
210401	Бичиг хэрэг	885,2
210402	Тээвэр, шатахуун	3,454,0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,200,0</b>
210604	Урсгал засвар	1,200,0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,560,0</b>
210702	Дотоод албан томилолт	2,560,0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6556,5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,556,5
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,463,8</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,463,8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>246,000,0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>246000,0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,000,0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	240,000,0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>59,506,0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>59,506,0</b>
223001	Бусад хөрөнгө	59,506,0
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>336,625,5</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>336,625,5</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	335,425,5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,200,0
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.5 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

### Залруулсан алдаа:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны хяналт шалгалтаар тогтоосон 1.5 сая төгрөгийн төлбөрийн актыг санхүүгийн тайлан бүртгэлд хувь хүмүүсээс авах авлага, байгууллагад төлөх өр төлбөрөөр тусгасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу залруулсан.

Аудитаар нийт 1 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. 2023 оны дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэл, хүрсэн үр дүнг үнэлж дүгнэхтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Дорнод аймгийн Баян-Уул сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “хангалттай” гэж дүгнэсэн нь бодитой биш байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** ИТХ нь хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг бодитой дүгнэж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хяналт шалгалтаар ирлүүлсэн зөрчлийг авлагаар тусгасан	1	1.5			1	1.5	1	1.5				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1.5</b>			<b>1</b>	<b>1.5</b>	<b>1</b>	<b>1.5</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

**БАЯН-УУЛ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй биелсэн	1	-	-	-	-	1	-	-	-	-	
<b>Дүн</b>	<b>1</b>					<b>1</b>	<b>1</b>			<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроосон	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Өмнөх аудитаар өгсөн алдаа зөрчлийг давтан гаргасан байна.	1	74.5	-	-	1	74.5	-	-
ОНХС-гийн 4 ажил хэрэгжээгүй	1	104.6			1	104.6		
ХХС-ний хугацаа хэтэрсэн авлага	1	50.6					1	50.6
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>229.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>179.1</b>	<b>1</b>	<b>50.6</b>
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>229.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>179.1</b>	<b>2</b>	<b>50.6</b>



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 01/ДОА-2024/01/НА/СТА-ТТЗ  
135 А 1170308,

Чойбалсан хот

Г Сахилгын хариуцлага тооцуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн 122.6 сая төгрөгийн татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлэх албан шаардлагын хэрэгжилтийг ханган ажиллаагүй. Тайлант онд малын тоо толгойн албан татвар 43.6 хувь буюу 66.1 сая төгрөгөөр, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 1.2 хувь буюу 8.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

Баян-Уул сумын Засаг дарга Х.Баттулга-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

011041263



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 03/186 ДОН-2024/01/НА-СТА-ТТЗ. Чойбалсан хот  
А1170308.

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр нийт 1,111.8 сая төгрөгийн 40 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 104.1 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөвлөсөн төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж хүрэх үр дүнг хангаж ажиллах, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-Уул сумын Засаг дарга Х.Баттулга, Санхүү албаны дарга Ж.Алтанцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АУДИТОР

Б.ОДХҮҮ



011041260

